


Баймж үг, бүтээврийн утга үүргийг мэдэх



Хичээлийн зорилго



01

Баймж утгын тухай
мэдэх

02

Баймж үг, бүтээврийн
утга, үүргийг мэдэх

03

Баймжийг эх өгүүлбэрт
хэрэглэх нь

Хоёр багана дахь өгүүлбэрийг харьцуулан уншаарай. Ямар ялгаа ажиглагдаж байна вэ?

1. Намайг энд байна гэж хэн хэлээ вэ?

-Сөөсгөр баавай л хэлээ биз

2. **Самдан:** -Дарга минь, намайг өршөөж хайрлаач. Би чинь нэгдүгээр ангийн ч боловсролгүй хүн шүү дээ.

Итгэлт: -Ядахдаа, тэр хуцны үр төлийг үлдээж авсан бол аштай юу?

Дамдин: - Ёстой, ёстой. Энэ хариуцлагагүй нөхрөөс л боллоо.

Самдан: -Дарга нар минь, алтан медальт хуцны үр төл ч харин олдож болох байх шүү.

Дамдин: -Юу ? Чи яаж олох юм бэ?
Гадаадаас худалдаж авах нь уу?

Самдан: -Үгүй дарга минь. Нөгөө Доржийн хэдэн хонь...

1.-Намайг энд байна гэж хэн хэлэв?

-Сөөсгөр баавай л хэллээ.

2. **Самдан:** - Дарга аа! Намайг өршөө. Би нэгдүгээр ангийн боловсролгүй хүн.

Итгэлт: - Тэр хуцны үр төлийг үлдээж авсан бол аштай.

Дамдин: -Энэ хариуцлагагүй нөхрөөс болов.

Самдан: - Алтан медальт хуцны үр төл олдож болно.

Дамдин: - Юу? Чи яаж олно? Гадаадаас худалдаж авна.

Самдан: - Дарга минь Доржийн хэдэн хонь ...

Баймж утга

Хүмүүс ертөнцийн юмс үзэгдлийг танин мэдэх, нийгмийн харилцаан дунд ажиллаж амьдрахдаа бодитой- хийсвэр, зайлшгүй- санамсаргүй , үнэн- худал, мөн чанар ба үзэгдэл, бодит байдал ба бололцоо зэргийн олон янзын асуудалтай тулгарч түүнд өөрийн бодол санаа, үнэлэмжээрээ ханддаг. Ийнхүү хандсанаа хэл яриагаараа илэрхийлэхдээ баталсан, няцаасан, эсвэл үнэмшсэн, итгэхгүй эргэлзсэн, таамагласан утга бүхий янз янзын үг хэллэгүүдийг хэрэглэдэг. Үүнийг баймж утга гэдэг ба баймж утга нь өгүүлэгчийн сэтгэлийн өнгө аясыг дэмжсэн шинжтэй илэрхийлэл байдаг.

- Аливаа баймжийг өгүүлбэр, цогцолборт хэрэглэснээр тэдгээрийн утга дэлгэрч, ойлгомжтой болохын зэрэгцээ найруулгын онцлог, өнгө аясыг тодотгодог.

Баймж нь эх өгүүлбэрт гишүүн болохгүй, үг
өгүүлбэрийг холбохгүй. Харин өгүүлэгч
этгээдээс уг үйл ба хэрэг явдалд хэрхэн
хандаж байгаа сэтгэгдэл, үнэлэмжийг
илтгэсэн хэлний нэгж юм.



Баймж нэгж

Бодит баймж

Уг үйл ба хэрэг явдлын үнэн бодитой болоход бүрэн илтгэсэн утгатай

Зайлшгүй баймж



Тухайн хэрэг ба үйл явдлын дотоод мөн чанарт түшиглэн, зайлшгүй байх зүй тогтлыг илэрхийлэх утгатай

Бололцоот баймж

Хэрэг ба үйл явдлын санамсаргүй хувирах боломжоос төрөх утга

Үнэн магадлалт баймж

Хэрэг ба үйл явдалд өөрийн болоод өрөөл бусдын үзэл бодлоос хандах санааг илтгэнэ.



Баймж утгыг илэрхийлдэг үг хэллэг

Бодит баймж	• Үнэхээр үнэндээ, үнэн хэрэгтээ, хэрэг дээрээ, хэрэг дээрээ, үнэнийг хэлбэл, үнэнээр өгүүлбэл, үнэн мөнөөрөө • Ний нуугүй хэлбэл, илэн далангүй яривал • Чухамдаа, чухамхүү, чухам нэг, ёстой нэг, бүр нэг, • Тийм нь тийм, мөн нь мөн • Шулуухан хэлбэл, шулуундаа бол	Зайлшгүй баймж	• -ууштай, -лтай, ёстой, хэрэгтэй, шаардлагатай, зохино, зохистой, зайлшгүй, хэрэггүй, учиртай, жамтай, зүйтэй, лавтай, зүй ёсоор, тэртэй тэргүй, заавал, эрхгүй, эрхбиш, өөрийн эрхгүй, аас аргагүй, -аас зайлшгүй яалт ч үгүй, эргэлзээгүй, гарцаагүй, мэдээжээр, мэдээжийн хэрэг, мөн дөө, маргаангүй, магадгүй, ерөөсөө, нэг үгээр хэлбэл, ихэнхдээ, ихэвчлэн, голдуу, голчлон, дандаа, хураангулбал, тухайлбал, өөрөөр хэлбэл, нарийвчилбал, нарийндаа, адаглаад, ядахдаа, ялангуяа, эцсийн эцэст, эцсийн бүлэгт, юуны өмнө, хамгийн түрүүнд, эхлээд, нэг талаар, нөгөө талаар, нөгөөтэйгүүр, адаг сүүлд нь, нэг бол, үгүй бол, явж явж, очиж очиж гэх мэт
Үнэн магадлалт баймж	Жишээ нь: Өөрийн үзлийг илтгэх: • Минийхээр, миний бодвол, миний бодоход, миний санахад өөрийнхөөрөө үзвэл, миний хүслээр бол, олон таван үггүй Бусдын үзлийг илтгэх: • Олны амаар бол, олны хэлэлцдэгээр, даргын хэлдгээр, Батын хэлдэг шиг, түүний жигээлснээр, дам сонсвол, номд дурдсанаар, тэдний өгүүлэх нь гэх мэт	Бололцоот баймж	Жишээ нь: Эргэлзэх ба таамаглах : болзошгүй, мэдэшгүй, магадгүй. Таамаглах : бололтой, боломжтой, бололцоотой, янзтай, шинжтэй, янз нь, бодлоор, царай нь, байдалтай, төлөвтэй, чадвал, - ж мэднэ, санаатай, болох юм, юм шиг бай-, Санамсаргүй тохиол: ашгүй, золоор, завшаанаар, эгээтэй л золтой л дашрамд, далимд нь, аштай юу, азаар, аз таарч, өөрийн эрхгүй, ялдамд, сохор азаар, санаандгүй, ерөөлөөр, нэг мэдэхнээ, мартсанаас гэх мэт

Баймжит бүтээврийн утга


1		А. Ерөнхийлөн асуух	уу ? , юу ?	Жишээ нь: Сайн байна уу? Сайн явж ирэв үү?
		Б. Ялган асуух	бэ?, вэ?	Ямар сайхан юм бэ? Яасан сайхан өдөр вэ?
2	Онцлох утгатай	Батлан онцлох	шүү, за	Би заавал очно шүү
		Магадлан онцлох	даг, даа,хуна	Тэднийг тэгэх тусам очно хуна. Үзнэ дээ.
		Салан онцлох	л,бол, хүртэл, гэж, гэдэг, гэгч, бээр, хүү минь	Ах л ирлээ. Дорж бол хүний мөсөөр сайн хүн.
		Зэрэгцүүлэн онцлох	Ч, \ чиг\ зэрэг, мэт- ийн	Ах чирлээ,, Би үзнэ ч, очно ч
		Ерөнхийлөн дуудах	аа	Дорж оо, барагтайхан шиг байгаарай.
		Ялган дуудах	минь	Өл буурал хангай минь өмөг түшгээ хайрлагтун.
3	Барагц аалах утга	Тааварлан барагцаалах	биз, буй, за	Уншина биз. Гэртээ харина биз.
		Төсөөлөн барагцаалах	шив, шиг, шүү	Бороо дуслах шиг боллоо.
4.	Адилтгах утга	Жишин адилтгах	мэт, шиг	Сар мэт гэрэлтэй. Хангай шиг түшигтэй.
		Эс тоомсорлон адилтгах	мэт , шүү	Энэ мэт нь яаж чадах вэ? Цүнх шүү юм ав
		Багасган адилтгах	-хан	Жижигхэн, томоохон, саяхан, дөрөвхөн, цагаахан , өчигдөрхөн , юухан

Баймжит бүтээврийн утга

5	Дурсан дурдах	Шууд дурсан дурдах	билээ, лээ, ажээ, аж, санжээ, санж	Тал сайхан нутагтай билээ. Чиний цүнх тэнд л байна лээ. Аав минь үүнийг өгсөн сөн.
		Дам дурсан дурдах	гэнэ	Эмгэн өвгөн хоёр амьдран суудаг байж гэнэ.
6.	Хүсэн баясах	Хүсэх	сан, сэн, сон, сөн	Эх нутгийнхаа сайхныг цөмийг нь үзэхсэн.
		Хөгжих хөхих	хө	Энд жимс ургадаг юм байна хө.
7	Батлах утга	Нотлох батлах	аа, еэ, \юм, мөн\ гэм гүм	Нохойн гөлөг ч хөөрхөн амьтан юм аа. Энэ Доржийн дүү мөн.
		Боломжийг батлах	нь, ээ, минь, чинь	Нар шарах нь ээ, шарах нь. Ингэж явснаас үхэх минь
8	Үгүйсгэх утгатай	Хориглох	бүү, битгий	Тамхи бүү тат. Аар саар юманд битгий бухимд .
		Үгүйсгэх	үл, эс, \гүй, биш, бус, гэж\	Хэн ч түүнийг үл мэднэ. Тэр явах биш, яах юм.
		Сануулан хориглох	вий	Чи тийшээ явна бий вий, Чи бүр ингэхдээ тулсан хүн бий

Онцолсон үгсийн утгыг ажиглаад, өгүүлбэрт ямар үүрэгтэйг тайлбарлаарай. Өгүүлбэрт ямар гишүүн болох вэ? Хасаж уншвал утга хэрхэн өөрчлөгдөж байна вэ? _

- Зуны цагт баруун дамнуурчны таван гудамжны шавар үлэмж үнэр ханхлах нь **үнэхээр**, түмэн багц хүжийг шатаавч үл дарагдмаар.
- **Ашгүй дээ**, хүн хэлбэртэй, гозгор хөх чулуу байж л байна.
- **Нэгэнт**, ийм сонин юм олж ирсэн болохоороо гялалзтал зүлгэж нямбайлаад хоймортоо тавив.
- **Нэг мэдэхэд**, нэг л танил дуутай хүн чухал юм яриад байх шиг байв.
- **Үнэндээ** ухаан санаанд багтахгүй юм байна.
- За ашгүй энүүгээр **л лав** явсангүй.
- **Магадгүй**, томоохон нээлтэд хүрэх зам нь тавигдах учиртай.



Баярлалаа